



**БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ
ИНСТИТУТИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2019 оны 01 сарын 02 өдөр

Дугаар A/01

Улаанбаатар хот

**Ажилтны хоол, унааны хөнгөлөлтийн
хэмжээг шинэчлэн тогтоох тухай**

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.3, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн хөдөлмөрийн дотоод журмын 5 дугаар зүйлийн 5.1.23, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажилтны нэг ажлын өдрийн хоолны хөнгөлөлтийн хэмжээг 4,500 төгрөг, унааны хөнгөлөлтийн хэмжээг 1,000 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосугай.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан институтийн захирлын 2015 оны "Ажилтны хоол, унааны хөнгөлөлтийн хэмжээг тогтоох тухай" A/72 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮРЭНЧИМЭГ